



## Бурхан бол Гайхамшигийг Бүтээгч Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

**Мөн чанар:** Бурхан бол Гайхамшигийг Бүтээгч

**Attribute:** God Is a Miracle Worker

**Тодорхойлолт:** Тайлбарлах боломжгүйг, ер бусыныг Бүтээгч Нэгэн.

**Эшлэл(үүд):**

- **1 Шастир 16:8-12** Аяа, ЭЗЭНд талархлыг өргөн Алдар нэрийг нь дуудан Ард түмний дунд үйлсийг нь мэдүүлэгтүн. Түүнд дуулж, Түүнд магтуу дууг дуулагтун. Түүний бүх гайхамшгуудыг яригтун. Түүний ариун нэрд алдар байг. ЭЗЭНийг эрэлхийлэгчийн зүрх баясах болтугай. ЗЭНийг хийгээд Түүний хүч чадлыг эрэлхийлэгтүн. Түүний нүүр царайг үргэлж хайгтун. ЭЗЭНий үйлдсэн гайхамшигт үйлсийг, Түүний тэмдгүүд болон Түүний амнаас гарах шүүлтүүдийг санагтун.
- **Дуулал 77:11-14** ЭЗЭНий үйлсийг би санана, Эрт үеийн гайхамшгуудыг тань үнэхээр санана. Таны бүх ажлыг би тунгаана, Таны үйлдлүүдийг шимтэн бодно. Бурхан, Таны зам ариун Бидний Бурханы адил, Бурхан шиг хэн аугаа вэ? Гайхамшгуудыг үйлддэг Бурхан Та Ард түмнүүдийн дунд Хүч чадалаа мэдүүлжээ.
- **Иеремиа 32:20** Та энэ өдрийг хүртэл Израильд ч, хүн төрөлхтний дунд ч Египетийн нутаг дахь тэмдгүүд болон гайхамшгуудыг тогтоожээ. Энэ өдөр байгаатай адил Та Өөртөө алдар нэрийг бүтээжээ.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

*Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.* 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.* 1 Тесалоник 5:18

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

**Өөрсдийн хүүхдүүдийн төлөө** — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

**Эшлэл(үүд):** Дуулал 77:11-12; Матай 10:7-8

**Библийн эшлэлээр залбирах:**

(Хүүхдийн нэр) маань ЭЗЭНий үйлсийг санан дурсах болтугай; Олоон жилийн өмнөх Таны гайхамшгуудыг санах болтугай; (Хүүхдийн нэр) маань Таны үйлсийг тунгаан бясалгаж, Таны хийсэн бүх үйлсийг бодох болтугай. Өө ЭЗЭН, (Хүүхдийн нэр) маань амьдралынхаа туршид энэхүү мэдээг тунхаглан явах болтугай: “Тэнгэрийн хаанчлал ирсэн байна.” Мөн Таны өгсөн эрх мэдлийн дотор өвчтэйг эдгээж, үхсэнийг амилуулж, уяман өвчтэй нэгнийг цэвэршүүлж, чөтгөрүүдийг хөөн зайлуулах болтугай.

**Залбирлын тодорхой хүсэлт:**

**Багш/Ажилчид** (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та \_\_\_\_\_-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Танд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- \_\_\_\_\_ маань ЭЗЭНий үйлсийг санан дурсах болтугай; Олоон жилийн өмнөх Таны гайхамшгуудыг санах болтугай; \_\_\_\_\_ маань Таны үйлсийг тунгаан бясалгаж, Таны хийсэн бүх үйлсийг бодох болтугай. Өө ЭЗЭН, \_\_\_\_\_ маань амьдралынхаа туршид энэхүү мэдээг тунхаглан явах болтугай: “Тэнгэрийн хаанчлал ирсэн байна.” Мөн Таны өгсөн эрх мэдлийн дотор өвчтэйг эдгээж, үхсэнийг амилуулж, уяман өвчтэй нэгнийг цэвэршүүлж, чөтгөрүүдийг хөөн зайлуулах болтугай. *Дуулал 77:11-12; Матай 10:7-8*

**Сургуулийн төлөө залбирах** – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

**Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах** — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

***Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!***